



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/538

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр
томилох тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.8, Яамны Хөдөлмөрийн дотоод журмын 5.15-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр тэмдэглэх баярын өдөр 2017 оны 12 дугаар сарын 29-31, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрүүдэд хариуцлагатай жижүүр хийх албан хаагчдын хуваарийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, эрүүл мэндийн байгууллагуудаас мэдээлэл авах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Яамны 11-323002 утсанд ирсэн санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох газар хэлтсийн дарга, Төрийн нарийн бичгийн даргад мэдээ өгч ажиллахыг хариуцлагатай жижүүр хийж үүрэг гүйцэтгэж байгаа газар, хэлтсийн мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

3. Хариуцлагатай жижүүрээр ажилласан мэргэжилтнүүдийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу нөхөн амруулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
 2017 оны 12 сарын 28-ны өдрийн
 А/538 ... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯР, АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД
 АЖИЛЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ**

№	Ажиллах цаг	Хариуцлагатай жижүүр хийх албан хаагч	Газар, хэлтэс	Хяналт тавих албан тушаалтан
2017 оны 12 дугаар сарын 29-ний өдөр				
1	08.00-16.00	Т.Жавзандулам	ЭТГ	Я.Буянжаргал
2	16.00-24.00	Ш.Лувсмаа	БТГ-ЭЗСХ	
3	24.00-8.00	А.Долгорханд	НЭМГ-ТШУХ	
2017 оны 12 дугаар сарын 30-ны өдөр				
4	08.00-16.00	Д.Уранчимэг	ТЗУГ	Р.Оюунханд
5	16.00-24.00	Ч.Амаржаргал	ЭҮТГ-ЭЭХХ	
6	24.00-8.00	Д.Мөнхцэцэг	ТЗУГ-ХХ	
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр				
7	08.00-16.00	Э.Оюунсүрэн	ЭҮТГ	Д.Нарангэрэл
8	16.00-24.00	Э.Баярмаа	БТГ-ХОХ	
9	24.00-8.00	Б.Долгорсүрэн	ЭТГ	
2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр				
10	08.00-16.00	Б.Чулуунбат	ХШҮДАГ	Л.Мөнхтулга
11	16.00-24.00	Б.Туяа	ТЗУГ-ГХАХ	
12	24.00-8.00	Т.Энхзаяа	НЭМГ	

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 12 сарын 28 -ны өдрийн
А/538 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

1. Яамны 11-323002 утсанд ирсэн санал хүсэлтийг хүлээн авч, зохицуулалт хийх, сайд удирдлагуудад танилцуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах,
2. Эрүүл мэндийн байгууллагуудаас өдөрт 2 удаа /08.00-16.00 цагийн мэдээг 17.00 цагт, 16.00-08.00 цагийн мэдээг 09.00 цагт/ тушаалын гуравдугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу мэдээллийг авах,
3. Авсан мэдээ мэдээллийг цаг, минуттай нь бүртгэж тэмдэглэл хөтлөх,
4. Шаардлагатай тохиолдолд газар, хэлтсийн дарга, Төрийн нарийн бичгийн дарга, Дэд сайд, Сайдад мэдээлэл өгч, заавар зөвлөмж авах,
5. Ажлын зайлшгүй шаардлагаар холбогдох мэргэжилтнийг дуудах, аппаратыг бүрэн бүрэлдэхүүнээр яаралтай цуглуулах тохиолдолд удирдлагад танилцуулан шуурхай зохион байгуулах,
6. Хариуцлагатай жижүүр дэвтэрт үйл явцын тайлан бичиж дараагийн жижүүрт хүлээлгэн өгнө.
7. Сүүлийн өдөр буух хариуцлагатай жижүүр нэгдсэн тайлан бичиж Төрийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.
8. Мэдээг 24 цагаар өгөх ба олон хүнийг хамарсан хордлого, осол гэмтэл, ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл гарсан тохиолдолд хугацаа харгалзахгүй удирдлагад яаралтай шуурхай мэдээлнэ.
9. Нийтийг хамарсан ноцтой тохиолдлын шалтгаан болон нас баралт бүртгэгдсэн үед тухайн хүний нэр, нас, хүйс, хаяг, оношийн талаар тодорхой мэдээлэл авч бүртгэх,
10. Эх, хүүхдийн нас баралт бүртгэгдсэн тохиолдолд холбогдох мэдээллийг дэлгэрэнгүй авч бүртгэнэ.
11. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Онцгой байдлын ерөнхий газартай холбогдон мэдээ, мэдээллийг солилцож, тэмдэглэл хөтөлсөн байна.



НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯР, АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД
АЖИЛЛАХ ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН
МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСНЭГТ /өдөр бүрээр/

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

1	Мэдээллийн асуумж		ҮНТЭ	ҮХТЭ	ҮЛТЭ	ГССҮТ	ХӨСҮТ	ХСҮТ	СЭМҮТ	ЭХЭМҮТ	АӨСҮТ	ЗӨСҮТ	ЦССҮТ	ГҮТ	ЭСҮТ	Хүүхдийн төв сувилал	НЭМҮТ	НЭМТ, амаржих газрууд	21 аймаг
	Түргэн тусламжийн дуудлага	Насанд хүрэгчдийн Хүүхдийн																	
		Осол гэмтэл																	
		Төрөх																	
		Хордлого (хоолны, архины, бусад хордлого)																	

МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСНЭГТ /өдөр бүрээр/

ймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

1	Мэдээллийн асуумж	Архангай	Баянхонгор	Баян-Өлгий	Булган	Говь-Алтай	Говь-Сүмбэр	Дархан-Уул	Дорнод	Дорноговь	Дундговь	Өвөрхангай	Өмнөговь	Завхан	Орхон	Увс	Сүхбаатар	Сэлэнгэ	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Төв	НЭМТ	1-р амаржих	2-р амаржих	3-р амаржих	Бүгд
2	Эмнэлэг, төвүүдийн яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлсэн өвчтний тоо	Насанд хүрэгчдийн Хүүхдийн	Түргэн тусламжийн дуудлага	Осол гэмтэл	Төрөх	Хордлого (хоолны, архины, бусад)	Бусад																				
3	Нийт төрсөн эхийн тоо Үүнээс: гэртээ төрсөн																										

